

## СОРТЫН БҮТЭЭГЧИЙН ЭРХИЙН ХҮСЭЛТ ГАРГАХ, ХҮСЭЛТЭД ШҮҮЛТ ХИЙХ ЖУРАМ

### Нэг. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь таримал ургамлын үр, сортын тухай хуулийн дагуу сортын бүтээгчийн эрхийн хүсэлт гаргах, хүсэлтэд шүүлт хийх үйл ажиллагааг зохицуулахад оршино.

### ХОЁР. СОРТЫН БҮТЭЭГЧИЙН ЭРХИЙН ХҮСЭЛТ ГАРГАХ

2.1. Сортын бүтээгч хавсралтын дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүсэлт гаргана.

2.2. Сортын бүтээгч хэдэн ч сорт дээр хүсэлт гаргаж болох бөгөөд сорт бүрт тус тусдаа хүсэлт ирүүлнэ.

2.3. Сортын бүтээгч хүсэлтийн хамт сортын тодорхойлолт, итгэмжлэлийн эрх, давуу эрхийн магадлагаа, хүсэлт гаргасан сортын ижил төстэй сортуудаас ялгагдах шинж тэмдгийн зураг, холбогдох бусад материалыг хавсаргана.

2.4. Сортын тодорхойлолт нь тусгайлсан техникийн асуулт бүхий сортын дэлгэрэнгүй тодорхойлолт бөгөөд ижил төстэй бусад сортоос онцгой ялгарах шинж чанар, давуу талыг бүрэн ойлгомжтой гаргасан цогц мэдээллийг агуулсан байна.

2.5. Хүсэлт гаргагч нь итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлж болно. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эрх, үүргийг Иргэний хуульд заасан шаардлага хангасан итгэмжлэлээр тодорхойлно.

2.6. Хүсэлт гаргагч хүсэлтдээ давуу эрхийн огноог нэхэмжилж болох бөгөөд энэ тохиолдолд давуу эрхийн огноо хүсэж гаргасан хүсэлтийн хуулбарыг хавсаргана. Давуу эрхийн огноог тогтоолгох хүсэлт гаргахад сортын бүтээгчийн хүсэлтэд олон улсын хайлт, урьдчилсан шүүлтийн дүгнэлтийг хавсаргана.

2.7. Сортын бүтээгчийн хүсэлтэд үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана.

2.8. Хүсэлтийг монгол хэлээр үйлдэх бөгөөд өөр хэлээр үйлдсэн тохиолдолд хүсэлт гаргагч Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд уг хүсэлтийг ирүүлсэн өдрөөс хойш 2 сарын дотор монгол хэлнээ хөрвүүлж өгнө.

2.9. Энэ журмын 2.8-д заасан хугацаанд хүсэлтийг хөрвүүлж өгөөгүй бол хүсэлт гаргаагүй гэж үзнэ.

2.10. Хүсэлт гаргагч хүсэлтийн талаар эцсийн шийдвэр гарах хүртэлх хугацаанд хүсэлтээ буцаан авч болно.

2.11. Сортын бүтээгч хүсэлтийг цахимаар гаргаж болох бөгөөд энэ тохиолдолд хүсэлт нь энэ журамд заасан шаардлага хангасан байна.

2.12 Энэ журмын 2.11-д заасан хүсэлтийг уян диск болон мэдээллийн цахим хэлбэрийн бусад хэрэгслээр ирүүлж болно.

2.13. Цахим хэлбэрээр ирүүлсэн хүсэлтийн эхний огноог тухайн хүсэлт энэ журамд заасан шаардлагыг хангасан бөгөөд шаардлагатай баримтуудыг

хавсаргасан нөхцөлд хүлээн авсан холбогдох ажилтны гарын үсэг, дугаар бүхий баримтыг үндэслэн тогтооно.

2.14. Сортын бүтээгчээс ирүүлсэн аливаа хүсэлтийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нийтэд мэдээлнэ.

## ГУРАВ. ХҮСЭЛТЭД ШҮҮЛТ ХИЙХ

3.1. Хүсэлтийн эхний огноог тогтоосны дараа Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам тухайн сортын бүтээгчийн эрхийн хүсэлт энэ журмын 2 дугаар бүлэгт заасан шалгуурыг хангасан эсэхэд шүүлт хийнэ.

3.2. Хүсэлт гаргагч мэдүүлсэн шинэ сортыг гадаад улс, олон улсын байгууллагад сортын бүтээгчийн эрх авахаар мэдүүлсэн бол энэ тухайгаа Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд мэдэгдэнэ.

3.3. Шүүлт хийх явцад буюу эцсийн шийдвэр гарахаас өмнө хүсэлт гаргагч анхныхаа ирүүлсэн тодорхойлолтын агуулгын хүрээнээс халихгүйгээр, хүсэлтээ нэмэлт, өөрчлөлт хийж болно.

3.4. Хүсэлт гаргагчийн хүсэлтээр шүүлт хийхийг хойшлуулж болох боловч шүүлт хийхийг хойшлуулах хугацаа нь энэ журмын 3.5, 3.6-д заасан хугацаагаар хязгаарлагдана.

3.5. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хүсэлтийн эхний огнооноос хойш 9 сарын дотор шүүлтийн дүгнэлтийг үндэслэн сортын хамгаалал олгох эсэх талаар шийдвэр гаргана.

3.6. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам шаардлагатай гэж үзвэл энэ журмын 3.5-д заасан хугацааг 12 сар хүртэл хугацаагаар сунгаж болно.

3.7. Сортын хамгаалал олгохоор шийдвэрлэсэн шинэ сортын нэр, тодорхойлолт, зургийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нийтэд зарлана.

3.8. Шинэ сорт болох нь нотлогдоогүй, хамгаалах боломжгүй бол сортын хамгаалал олгохоос татгалзсан шийдвэр гаргах бөгөөд шүүлтийн дүгнэлтийн хуулбарыг уг дүгнэлт гарсан өдрөөс хойш 30 хоногийн дотор хүсэлт гаргагчид хүргүүлж, хүсэлтийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хадгална.

Сортын бүтээгчийн эрхийн хүсэлт гаргах загвар

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

СОРТЫН БҮТЭЭГЧИЙН ЭРХИЙН ХҮСЭЛТ ГАРГАХ

**ЗӨВХӨН АЛБАН ХЭРЭГЦЭЭНД**  
**Санамж : Хүсэлтийн загварыг сайтар уншсаны**  
**дараа компьютероор бөглөнө үү!**

Хүлээж авсан огноо<sup>1</sup>: .....

Өргөдлийн дугаар<sup>1</sup>: .....

1. Бүртгүүлэх тухай хүсэлт

Бүтээгчийн эрх авахаар бүртгүүлж.....сортын нэр бүхий бүтээгчийн эрхийн гэрчилгээ авах хүсэлтийг үүгээр гаргав.

---

2. Хүсэлт гаргагч – Сортын бүтээгч<sup>2</sup>

2.1. Овог нэр:<sup>3</sup>

2.2. Хаяг:

Утас:

Факс:

И-майл хаяг:

Регистрийн дугаар:

2.3. Иргэншил:

Оршин суудаг Улсын нэр:

2.4. Бүртгүүлсэн улс:

2.5. Итгэмжлэгдсэн төлөөлөгч ашиглах эсэх

Тийм  Үгүй

2.6.  Нэгээс дээш хүсэлт гаргагч байгаа бол энэ хэсэгт дээр дурдсан мэдээллийн дагуу дараалуулан бичнэ.

---

<sup>1</sup>Зөвхөн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам бөглөнө

<sup>2</sup>."сортын бүтээгч" гэж сортыг бүтээсэн, эсхүл нээн илрүүлж сайжруулсан хувь хүн, хуулийн этгээд; сортыг бүтээсэн этгээдийн ажил олгогч, түүнчлэн гэрээслэх, бэлэглэх, солилцох, худалдах замаар эрхийг шилжүүлэн авсан этгээдийг;

<sup>3</sup>Хэрэв хүсэлт гаргагч нь хуулийн этгээд бол түүний оноосон нэр ба зохион байгуулалтын хэлбэр, хувь хүн бол түүний эцэг(эхийн) нэр ба өөрийн нэрийг энд бичнэ.

---

3. Итгэмжлэгдсэн төлөөлөгч<sup>4</sup>

3.1. Нэр

3.2. Хаяг:

Утас:

Факс:

И-майл хаяг:

3.3. Нэр, хаяг нь:

Хүсэлт гаргагчийнх

Итгэмжлэгдсэн төлөөлөгчийнх

3.4.  Итгэмжлэлийг хавсаргасан.

---

4.

4.1. Ургамлын латин нэр:

4.2. Түгээмэл /нийтлэг/ нэр:

---

5. 5.1. Санал болгож буй сортын нэр/ том үсгээр/ :

5.2. Бүтээгчийн лавлагаа:

---

6. 6.1. Сортыг бүтээсэн, эсхүл нээн илрүүлж сайжруулсан хувь хүн, хуулийн этгээд нь

Хүсэлт гаргагч  Дараах хүн байна: \_\_\_\_\_

6.2. Сортыг бүтээсэн, эсхүл нээн илрүүлж сайжруулсан өөр хувь хүн, хуулийн этгээд байхгүй.

6.3. Сортыг бүтээсэн, эсхүл нээн илрүүлж сайжруулсан хувь хүн, хуулийн этгээд нь шилжүүлсэн бол хүсэлт гаргагчийн:

гэрээ:

залгамжлал:

бусад / тодорхой бичих/:

6.4. Сортыг бүтээсэн улс:

---

<sup>4</sup>Хэрэв хүсэлт гаргагч нь өргөдлөө өөрийгөө төлөөлүүлэн тусгай зөвшөөрөл бүхий итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан гаргаж байгаа бол энэ хэсгийг бөгөлнө

7.

Бусад хүсэлтүүд	Хүсэлт гаргасан улс, олон улсын байгууллага/ хугацаа	Хүсэлтийн дугаар	Үе шат <sup>5</sup>	Сортын нэрэнд өгсөн бүтээгчийн лавлагаа
7.1. Хамгаалалт				
7.2. Албан ёсны сортын жагсаалт				

8. Хүсэлтийн дагуу давуу эрхийг \_\_\_\_\_ (улс, олон улсын байгууллагад) (эхний хүсэлт) \_\_\_\_\_ (хугацаа) \_\_\_\_\_ сортын нэрээр нэхэмжилсэн болно.  
Хүсэлт гаргасан огноо бүхий эхний хүсэлтийн хуулбарыг давуу эрхийн магадлагаанд шаардана.

9. Сортын үржүүлгийн материал болон ургацыг

- сортын бүтээгч өөрөө эсхүл түүний зөвшөөрлөөр бусдад борлуулаагүй, тараагаагүй.
- сортын бүтээгч гэрээний үндсэн дээр зах зээлд нийлүүлээгүй.

Улс, олон улсын байгууллага \_\_\_\_\_

Огноо \_\_\_\_\_

Сортын нэр: \_\_\_\_\_

10.

10.1. Сортын техникийн үзлэг

дууссан \_\_\_\_\_

дууссан огноо (мэдэж байгаа бол) \_\_\_\_\_

явагдаж байгаа \_\_\_\_\_

эхэлсэн огноо (мэдэж байгаа бол) \_\_\_\_\_

хараахан эхлээгүй.

<sup>5</sup> Үе шатыг дараахь байдлаар үнэлнэ. Үүнд:

А-хүсэлт хүлээгдэж байна.

В- хүсэлт цуцлагдсан.

С-хүсэлт татгалзсан.

Д-таримал ургамлын бүтээгчийн эрхээр хамгаалагдсан эсвэл уг сорт албан ёсны хамгаалагдсан сортын жагсаалтад бүртгэгдсэн.

10.2. Би/бид эхний хүсэлтийн материал нь энэ хүсэлтэй ижил болохыг үүгээр нотолж байна.

10.3. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь Ургамлын шинэ сортыг хамгаалах олон улсын холбооны /UPOV/ гишүүн оронтой уг шинэ сорттой холбоотой шаардлагатай мэдээлэл, материалыг солилцох зөвшөөрөл олгосон болно.

---

**11. Хавсаргасан материал**

11.1.  Сортын тодорхойлолт

11.2.  Итгэмжлэлийн эрх

11.3.  Давуу эрх

---

**12. Би/Бид үүгээр таримал ургамлын сортын бүтээгчийн эрх авах хүсэлт гаргаж байна.**

Би/Бид үүгээр уг загварын дагуу хүсэлтэд шүүлт хийхэд шаардлагатай мэдээллийг үнэн зөв, бүрэн бөглөснөө нотолж байна.

---

Байршил

---

Огноо

---

Гарын үсэг